

МОНГОЛ ДАХЬ ЯПОНЫ ФИЛОСОФИЙН СУДАЛГААНЫ ТОЙМ

М.ЗОЛЗАЯА

Доктор (Ph.D), дэд профессор
ШУА-ийн Философийн хүрээлэнгийн ЭНБД

Товч агуулга: XX зууны эхэн үеэс Японы философич эрдэмтэд дэлхийн философийн онолыг янз бүрийн хэлээрх эрх сурвалжид тулгуурлан судалж, өөрсдийн онцлог бүхий үр дүнг олон улсын түвшинд толилуулсаар байна. Японы философичид өөрийн оронд Хятад, Энэтхэг, Солонгос, барууны философийн ололтыг түгээдэг. Тэд бусад орны философичдын үзэл санааг баяжуулах замаар философи сэтгэлгээний түүхээ хөгжүүлсэн юм. Японы философи гэж ойлголт бол хүн төрөлхтний сэтгэлгээний түүхийн бүтээлүүдэд хэдийнээ багтаж танил болсон бөгөөд философийн нэвтэрхий толиудад ч түгээмэл тусжээ. Тус илтгэлд манай оронд эхлэл төдий байгаа Японы философи болон ёс зүйн судалгааны тоймыг авч үзэхийг хичээсэн болно.

Түлхүүр үгс: Японы философи, ёс зүйн боловсрол, ертөнцийг үзэл үзэл, ёс зүйн сентиментализм

Юуны өмнө орон судлалын асуудлыг философи арга зүйн үүднээс судлах, тодруулан харах бололцооны тухайд холбогдуулан хэдэн санааг хэлье. ЮНЕСКО-гийн 2005 оны Ерөнхий чуулганаар “философи нь хүүхэд залууст шүүн шинжилсэн үзэл бодол, ухаалаг, бүтээлч чадварыг төлөвшүүлдэг бөгөөд хүлээцтэй чанар, энх тайвныг хөхиүлэн дэмждэг салбар юм” хэмээн философийн үүрэг, ач холбогдлыг өндөр үнэлсэн юм. Түүнчлэн “Философийн хэрэглээ бол нийгмийг бүхэлд нь сайжруулах нэг арга зам. Хүмүүс ба соёл хоорондын гүүр бий болгоход тусалдаг” гэж дүгнэжээ. Эндээс философийн олон янзын урсгал чиглэл нь бүтээгчийн болон тодорхой орон зайн соёлын хандлага, үнэлэмжийг тусгахаас гадна соёлын олон талт байдалд хүлээцтэй хандах арга замыг төлөвшүүлэхэд чухал үүрэгтэй. Германы өнөө үеийн нэрт философич Волкер Герхардт

“Философийн гол үүрэг бол философийн янз бүрийн уламжлалыг өөр өөр иргэншилд нээлттэй байршуулж, тэдний үзэл санааг нээн илрүүлэх замаар орчин үеийн ач холбогдлыг нь бий болгох явдал юм. Философи нь танин мэдэхүйн олон янзын сонирхол, аргыг хүндэтгэдэг салбар. Философи ганц арга зүйг хэрэглэх л юм бол нэг л соёлыг бий болгоно, аажмаар уруудан доройтоход хүргэнэ¹ хэмээсэнтэй санал нийлэн дараах үндэслэгээнүүдийн тодруулга болгон дэвшүүлж байна.

Гадаад орон судлалын хүрээнд аливаа ард түмний философи сэтгэлгээний өв, уламжлалын судалгааг ямар нэг байдлаар авч хэлэлцэхийн тулд:

Нэг. Философи нь ертөнцөд хүний эзлэх байр суурь, танин мэдэхүй, оршихуй, соёл хоорондын шүтэлцээ ба тэдгээрийн олон янз байдал, мөн чанар, харилцаа зэргийг эргэцүүлдэг салбар ухаан болохын хувьд дэлхийн улс орнуудын хүн ардын ертөнцийг үзэх үзэл, соёлын хандлага, харилцан ойлголцлын түвшнийг судлах арга зүйн ач холбогдолтой.

Хоёр. Философийн түүх, үзэл санааны тухай танин мэдэх замаар тухайн улс, үндэстний сэтгэлгээний онцлог, өөрчлөлтийг илүү өргөн хүрээнд ойлгоход дөхөм үзүүлж болох юм.

Гурав. Философийн академик судалгаа нь өнгөрснийг орчин үеийн үүднээс эсвэл байгаагаар нь тайлбарладаг. Иймд философи сэтгэлгээний хэв маягаас тухайн ард түмэн, бүс нутаг эрин цаг үеэ бүтээсэн үзэл санааны түүх, төрийн бодлогынх нь мөн чанарыг ойлгох боломжтой. Гэхдээ үндэстэн, ард түмэн бүхэн философийг бүтээгч биш гэдгийг бид мэднэ.

Дөрөв. Соёлын адилсал, ондоошил нь философийн уламжлал эсвэл харилцан нэвтрэхэд нөлөөлж байдаг. Энэ үүднээс дорно дахины философийн ай савд хамаарах философи сэтгэлгээг бид хамтдаа бүтээж, хөгжүүлж, түгээж ирсэн гэж болох юм. Мөн дээр дурдсан энх тайван, соёл хоорондын гүүр, үзэл санааны түүх зэрэг нь олон улсын харилцаа, орон судлалын түлхүүр ойлголт болж байдгийг ч анхаарууштай.

Японы философи, хөгжлийн үе шат: Японы философийн түүхийн үе шатыг сонгодог үзэл санаа, орчин үеийн философи, өнөөгийн философи гэж хуваадаг. Сонгодог үе шатад, Зүүн Азийн оюун санааны уламжлалын үүднээс онолын сэтгэлгээг тайлбарласан. МЭ VI зууны үед буддизм дэлгэрч дорно дахины философийн гол урсгал чиглэлийн хөгжилд шинэ өнгө төрхийг нэмж, өөрийн соёл, философийг илүү өргөн хэлэлцэж хөгжүүлэхэд хувь нэмэр оруулжээ. VII-XVIII зууны соёлын хүрээнд Японы сэтгэгчид үндсэндээ күнзийн үзэл, хятадчилагдсан буддизм, хятадын

¹ Волкер Герхардт: Үнэндээ Ницше, Кант хоёр маш төсөөтэй. Орч. Золзаяа М. <http://mongolianphilosophy.org/133.html>. 2022.12.29.

сонгодог бичвэрүүдийг судалсан ажээ. Гэхдээ судлаачид япончууд бол хятадын сэтгэгчдийг идэвхгүй дагагч биш, Зүүн Азийн хүрээнд философийн сэтгэлгээг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулсан гэж үнэлдэг байна. Эдогийн үед (1603–1868) зарим сэтгэгч уугуул соёлоос холдож эхэлсэн бөгөөд өрнийн мэдлэгийн тогтолцоон дээр суурилж Японы нийгмийн орчин үежилтийг өрнийн үзэл санаагаар чиглүүлж байжээ. Японы философийн хоёр дахь буюу орчин үе нь Мэйжигийн үеийн (1868–1912) өрнийн философийг эрчимтэй нэвтрүүлснээр эхэлдэг. Үүний үр дүнд дорнын болон өрнийн үзэл санааг шүтэлцүүлж, XX зууны эхний хагаст энэ чиглэлийн бүтээлүүд гарч эхэлсэн. Японы нэрт философич Нишида Китарогийн (1870–1945) нөлөөгөөр өрнийн философийг дэлгэрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Киотогийн философийн сургууль дорнын уламжлал, ялангуяа их хөлгөний буддизмаар философид хувь нэмэр оруулж, XX зууны дунд үе хүртэл нэр хүндтэй байв. Японы философийн гурав дахь буюу орчин үеийн үе шат нь дайны дараах Японы сэргээн босголтоос өнөөг хүртэл үеийг хамрах бөгөөд нэр хүндтэй судлаачид Токиогийн Их сургуульд төвлөрч, дорнын уламжлалаас нэлээд холдож, аналитик эсвэл эх газрын контекстийн хүрээнд философийн судалгааг удирдан явуулж байна. Японд сүүлийн үеийн философийн судалгаа сайн үр дүнд хүрч байгаа ч бүтээлүүдийнх нь талаар гадаадад бага мэддэг.² Иймд 2014 онд харьцуулсан философийн судалгаа болон японы философийн чиглэлээр ажилладаг судлаачид Японы Философийн Европын сүлжээг (ENOJP) үүсгэн байгуулжээ. Тус байгууллагын гол зорилго нь европын хэлээр японы философийг сурталчлах, эрдэмтдийг дэмжихэд чиглэдэг байна. ENOJP нь “Европ дахь японы философийн сэтгүүл” (EJJP) гаргах, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, судалгааны төслүүдийг санаачлах, сэдэвчилсэн эсээ, орчуулгын өгүүлэл нийтлэх зэрэг үйл ажиллагаа явуулдаг байна. Энэ бол өөрийн оронд философийг хөгжүүлэх, мөн өөрсдийн үзэл санааг бусдад таниулах арга зам юм.

Японы философийн судалгаа: Буддизм бол Ази, дорно дахины улс орнуудад дэлгэрсэн хүн төрөлхтний сэтгэлгээний ололт юм. Иймд бид монголын буддын философи судлаачдын бүтээлд японы буддизмын судалгаа хэрхэн туссаныг авч үзэх шаардлагатай. 1990 оноос хойших буддын философийн судалгаанд Японы эрдэмтдийн англи хэлээр хэвлэгдсэн бүтээлийг ашиглаж эш татсан байна. Тухайлбал, профессор Г.Лхагвасүрэн агсны “Сэтгэл төдийтний гүн ухаан” бүтээлд Масааки Хатторигийн буддын логик (Dignaga: On perception. Cambridge, Mass.

² Tomomi Asakura. Japanese Philosophy. <https://www.oxfordbibliographies.com/display/document.2022.12.15>.

1968), Такакусу Жунжиро (The Essentials of Buddhist philosophy. Greenwood press, 1973), Г.Нагао (Madhyamaka and Yogachara. A study of Mahayana Philosophies. Collected papares. Suny series in Buddhist Studies. Albany, 1991) зэрэг бүтээлийг ашиглажээ. Зохиогч бичихдээ, Г.Нагао "сэтгэл төдийтний гүн ухаан судлалын талаар өнөөгийн дэлхийн буддын судлалын хүрсэн түвшнийг тусган илэрхийлсэн, төв үзлийн аспектаар бол Г.Нагаогийн судалгаа төдийлөн шинэлэг бус, тухайлж төв үзлийн талаарх монголын буддын судлал, түүний эл баримтлалаас илүүтэй гүнзгийрсэн шинжтэй. Мөн сэтгэл төдийтний хувьд сэтгэлгээний аргын үүднээс өгсөх хийгээд уруудах хэмээх хоёр ойлголтын нэгдэл гэж тодорхойлсон нь түүний судалгааны гол үр дүн гэж дүгнэсэн байна.³ Профессор Ж.Такакусу чүшэ, чэншин, санлун, хуаен, тиантай, шэнен, чань зэрэг хятадын болон японы буддизмын чиглэлийг судлаад, сэтгэл төдийтний гүн ухаан бол реалист ба нигилизмын дундыг барьсан шинжтэй репрезентатив идеализмын сургаал⁴ гэж дүгнэснийг ч авч үзжээ.

Манай философичид 1990-ээд оноос өмнө Азийн Буддистуудын Энх Тайвны Бага Хурлаар дамжуулан японы эрдэмтэдтэй буддын шашин, философийн талаар холбоо харилцаатай байжээ. Академич Ч.Жүгдэр агсан АБЭТБХ-ын нарийн бичгийн дарга байхдаа 1983 оны 07-р сарын 29-өөс 08-р сарын 12-ны өдөр Японд болсон Атом устөрөгчийн бөмбөгийг эсэргүүцэх олон улсын хуралд оролцож байсан бол,⁵ 1985 оны 05-р сарын 10-ны өдөр цөмийн зэвсгийг хориглож, устгах тухай японы дэвшилт олон нийтийн байгууллагуудаас гаргасан Хирошима, Нагасакигийн уриалгыг тус бага хурал дэмжиж байгаа тухай мөн Ч.Жүгдэрээс Токио хот дахь Японы үндэсний төвд цахилгаан ирүүлснийг ЯКН-ын "Акахата" сонинд товч мэдээлсэн⁶ ажээ.

XX зууны японы философичдын үзэл санааг системтэй судалж бүтээл туурвил гаргах ажил эхэлсэн байна. МУИС-ийн багш, доктор Д.Оюунгэрэл англи, орос, япон хэл дээрх судалгааны эх сурвалжийг ашиглан Нишида Китарогийн философийг судлан "Нишида Китарогийн философийн үзлийг шүүн шинжлэх нь" (МУИС, 2011) сэдвээр эрдмийн зэрэг хамгаалж, өгүүлэл, илтгэлийг хэвлүүлжээ.⁷ Түүний хүний ахуйн

³ Лхагвасүрэн Г. (2010). Сэтгэл төдийтний гүн ухаан. Ред. Чулуунбаатар Г. Улаанбаатар, Соёмбо принтинг, 48-49.

⁴ Мөн тэнд, 49.

⁵ Сэржав Б., Загдцэсэм У., Болормаа М., Сосорбурам А. (2022). Монгол, Японы харилцаа. Он дарааллын товчоон 1972-2022. Эмх. ШУА-ийн ОУСХ. Улаанбаатар, Бэмби сан, 187.

⁶ Мөн тэнд, 223.

⁷ Оюунгэрэл Д. (2007). Нишида Китаро ба XX зууны Японы философи. Философи, шашин судлал. №288 (41)., Оюунгэрэл Д. Нишида Китарогийн философийн үзлийн ач холбогдол. (2013). Шинэ зууныг угтсан Монгол, Япон. Монгол, Японы залуу судлаачдын анхдугаар форумын эмхэтгэл. Улаанбаатар.

тухай үзэл баримтлал, нийгэм-ёс зүйн үзлийг нь судалж, хүний ахуй, ёс зүй, шашны болон үндэсний үзлийн ээдрээтэй асуудлыг нь гүнзгийрүүлэн тайлбарлаж⁸ улмаар “Нишида Китарогийн философийн үзлээс” хэмээх нэгэн сэдэвт бүтээл хэвлүүлсэн. Зохиогч Китарогийн философийг өөрийн үзэл бодлоор тольдон тайлбарлаж, үнэлэлт дүгнэлт өгсөн нь чухал ач холбогдолтой болсон юм.

Р.Дарьхүү, Г.Эрдэнэбаяр нарын “Философийн түүх” гэсэн (УБ.,2004, 2006, 2014, 2016) сурах бичигт⁹ Япон оронд даосизм, Күнзийн сургаал, нео күнзэч сургаал, инь-яны сургаал, чань буддизм хүчтэй дэлгэрсэн, япончууд эдгээр сургаалыг үндэсний уламжлалт сэтгэлгээ, соёлд шингээх байдлаар хүлээж авсныг тайлбарласан байна. Зохиогчид Мэйжигийн өөрчлөлтийн өмнөх үе буюу 538-1867 он (эртнээс дундад зуун), Мэйжигийн өөрчлөлтөөс эхлэн орчин үе хүртэлх буюу 1868 оноос орчин үеийг хамруулж, дундад зууны сюсигаку, оемейгаку, кокугаку, японы материализм, зэн буддизм гэсэн чиглэлээр хөгжсөн тухай, күнзийн сургаал, буддизм нэвтрэхээс өмнөх үеийн эртний япончуудын сэтгэлгээг тусгасан “Эртний явдлын товчоо”, “Японы товчоо бичиг”, “Эртний дууны түүвэр” зэрэг бүтээл зэргийг дурджээ. Тус сурах бичигт зэн буддизм, самүрайн философи, сюсигаку, оемейгакугийн гол төлөөлөгчдийн үзэл санааны тухай тусгайлан зүйл болгож бичжээ. Эндээс Мэйжигийн өөрчлөлтийн өмнөх үеийн японы философи нь бусдын соёлын хөрсөнд бий болсон үзэл санааг өөриймшүүлэх арга, ингэхдээ тухайн нийгмийн нөхцөл байдлыг эргэцүүлж, ямар үзэл санааг эзэмших тухайд илүү прагматик байр сууринаас хандаж байсан. Тухайлбал, үндэсний нэгдлийг хангах, нийгмийн цөхөрсөн сэтгэл зүйн байдлыг даван туулах, үхэл амьдралын зааг дээрх үед хэрхэн сэтгэлийн амар амгаланг хүсэх, ёс суртахуунлаг, шударга нийгмийг байгуулах, дотоод сэтгэлээ ойлгох арга замыг төгөлдөржүүлэх асуудлыг дэвшүүлсэн байна.

Фүкизава Юкичигийн “Эрдмийг эрхэмлэх ухаан”¹⁰ хэмээх соён гэгээрүүлэх сургаалын зохиол, Сато Чиэгийн “Харвардын япон судлал: Япон хүн гэж хэн бэ?” хэмээх бүтээлүүд орчуулагдсан нь манай уншигчдын сонирхлыг татаж байгаа бөгөөд япончуудын ертөнцийг үзэх үзэл, сэтгэлгээний өөрчлөлтийг философийн үүднээс судлах хэрэглэгдэхүүн болно. Мөн бизнесийн ёс зүйн янз бүрийн сургалтын гарын авлагуудад японы ёс зүйн талаар дурдагдсан байдаг.

М.Саранцэцэг 2014 онд “Японы философи сэтгэлгээний түүхэн

⁸ Оюунгэрэл Д. (2017). Нишида Китарогийн философийн үзлээс. Ред. Дарьхүү Р. Улаанбаатар, Тотопресс, 7.

⁹ Дарьхүү Р., Эрдэнэбаяр Г. (2016). Философийн түүх. 4 дэх хэвлэл. Ред. Лодой Г. нар. Улаанбаатар.

¹⁰ Фүкизава Юкичи. (2014). Эрдмийг эрхэмлэх ухаан. Орч. Жаргалсайхан О. Ред. Даш-Ёндон Б. Улаанбаатар, Адмон ХХК.

тойм" хэмээх гарын авлагадаа эртний япончуудын философи сэтгэлгээг Тайкагийн үеийн философи сэтгэлгээ, Нарагийн үеийн философи сэтгэлгээ, Хэйаны үеийн философи сэтгэлгээний үүсэл, хөгжлийг тэр үеийнх нь нийгэм-улс төр, соёл, эдийн засгийн нөхцөл байдалтай¹¹ холбон авч үзсэн.

Мөн манайд зэн буддизмын чиглэлээр орчуулгын бүтээл, гарын авлагууд хэвлэгдсэн.¹² Зохиолч Г.Аюурзана¹³ орчин үеийн барууны ертөнцөд зэн буддизм хэрхэн нөлөөлж буй тухай, зэнгийн урсгалын мөн чанар, онцлог, "коан" хэмээх сатори-д хүргэх (агшин зуурын гэгээрэл) хэвшмэл логик сэтгэлгээнээс эрс ондоо утга бүхий, оньсого мэт нууцлаг этгээд хэлц яриа, таавар, парадокс сэтгэлгээний мэтгэлцээний талаар өгүүлсэн нь уншигчдын сонирхлыг татсан байна.

Нишида Китаро нь хувь хүний ёс суртахууны түвшин нь хүн өөрийгөө үнэлэх, өөрийгөө хянах, өөрийгөө танин мэдэх гэж¹⁴ ангилсан байдаг. Японд өөрийн хүмүүжил, өөртөө хандах бие даасан үзэл бодолд тулгуурласан сургаалууд хөгжсөн байдгийн нэг жишээ нь **зэн буддизмын ёс зүй** юм. Судалгааны явцад зэн буддизм эсвэл японы философи нэрийн дор хэвлэгдсэн зарим бүтээл эзотерик, магадгүй шашны сургаалд нэлээд хэлбийсэн талтай юмуу гэсэн бодол төрж байв.

Японы уран зохиолын, бие хүний хөгжлийн талаарх номууд монгол хэлээр орчуулагдаж байна. Японы уран зохиол нь нийгмийн түгээмэл асуудлыг хөндөж, дэлхий нийтийн анхааралд хүргэдэг, бусад орны хүн ч ойлгон хүлээж авах зохиомжтой.¹⁵ Ер нь философийн агуулгатай санааг нэлээд дэвшүүлдэг тул японы зохиолчдын намтар судлалд философийн үзэл, хандлагыг нь тодруулбаас утга зохиол шүүмжийн сонирхолтой дүгнэлт, санаа гарах буй за.

Философийн судалгаа гэж ярьж байгаа тохиолдолд ёс зүй, гоо зүй, логикийн судалгааг хамруулж үзэхээс аргагүй. Манай эрдэм шинжилгээний мэргэжлийн сэтгүүлүүдэд японы ёс зүйн сэтгэлгээний цөөн боловч өгүүлэл, илтгэл хэвлэгдсэн байна. Эдгээр нь япон судлаачдын оролцоотой хийгдсэн байгаа нь сайшаалтай. Японы философийн талаар 1990-ээд оноос хойш бичигдсэн өгүүлэл, илтгэл нь орос хэлээрх хэрэглэгдэхүүнийг голчлон ашиглажээ.

Японы ёс зүйн (*rinrigaku*) боловсролын тухай судалгаа: Япончуудын ёс

¹¹ Саранцэцэг М. (2014). Японы философи сэтгэлгээний түүхэн тойм. Тэргүүн боть. Хянан тохиолдуулсан Дарьхүү Р. Улаанбаатар, Соёмбо принтинг.

¹² Насанжаргал Э. ба бус. (2011). Зэнгийн амьдрал. Улаанбаатар, Женерал принтинг.

¹³ Гүн Аюурзана. (2010). Зэн-Буддизм: Амьдралаас ангижрахуй. Улаанбаатар.

¹⁴ Оюунгэрэл Д. (2017). Нишида Китарогийн философийн үзлээс. Ред. Дарьхүү Р. Улаанбаатар, Тотопресс, 76.

¹⁵ Сато Чиз. (2021). Харвардын Япон судлал. Япон хүн гэж хэн бэ?. Орч. Тэмүүлэй М. Улаанбаатар, Монсудар, 259.

суртахууны төлөвшил, хандлага, японы ёс зүй нь судлаачдын сонирхлыг татсан сэдвийн нэг билээ. Тухайлбал, мэргэжлийн ёс зүйн боловсролын туршлагыг нь судлахад анхаарал хандуулсны жишээ бол академич Ж.Амарсанаагийн санаачилгаар Японы Хуульчийн ёс зүйн судалгааны хүрээлэнгээс хэвлүүлсэн “Хуульчийн ёс зүй” номыг 2007 онд орчуулан хэвлүүлжээ.¹⁶ Энэ нь Японы хуульчийн ёс зүйн боловсролын туршлагаас суралцахад чухал гарын авлага болно.

Японы нэрт эрдэмтэн, нийгмийн зүтгэлтэн Нитобэ Иназогийн (1862-1933) туурвисан “Бүшидо” хэмээх номыг япон судлаач Д.Төмөрбаатар монгол хэлээр орчуулсан.¹⁷ Уг номд бүшидогийн уг гарваль, ёс горим, нийгэмд үзүүлсэн нөлөө, самуурайн хүмүүжил төлөвшлийг шашин, ёс зүй, философийн үүднээс үндэслэн тайлбарласан байдаг. Зохиолд XIX зууны Японы нийгмийн ёс суртахуунгүй байдлыг хэрхэн шүүмжилж, өөрийн үндэсний ёс зүйн түүхээ эргэн харахыг анхааруулж, христийн шашныг дэлгэрүүлэгчид үндэсний ёс зүйн сэтгэлгээг ч харгалзах шаардлагатайг өгүүлсэн байдаг.¹⁸

2009 онд Р.Дарьхүү, Б.Оюунцэцэг нар японы ёс зүйн боловсролын стандартыг судлаад бага ангид хүнтэй мэндлэх, хүнийг хайрлах, хүндлэх зэрэг амьдралын зөв дадал, нийгмийн амьдралын дэг журмыг эзэмшүүлж, сайн мууг ялгах, хүний ёсонд харш зүйл хийхгүй байх, дунд ангид хамт олон, нийгмийн журмыг сахиж, бусдад туслалцаа үзүүлэх, ахлах ангид хууль дүрэм журмын утгыг ойлгож, бусдын байр суурийг ойлгох, харилцан дэмжих, нийгэм, хамт олны өмнө өөрийн хүлээх үүрэг, хариуцлагыг биелүүлж, эх орныхоо иргэн, нийгмийн нэг гишүүн гэдгээ ухамсарлахад хамаарах ёс суртахууны хэм хэмжээг ойлгуулахад анхаарч, сургууль бүрийн бодит байдал, нийгмийн хэрэгцээ, орчинд нийцүүлсэн заах арга зүйг боловсруулдаг¹⁹ хэмээн дүгнэжээ. Япон Улсын хувьд ёс зүйн боловсрол нь сургуулийн орчинд ёс зүйн цагийг гол тулгуур болгон нийт сургалт, хүмүүжлийн ажлаар хэрэгждэг гэж тодотгосон байна.

Р.Дарьхүү, Б.Оюунцэцэг нар “Ёс зүйн боловсролын асуудалд” өгүүлэлдээ Япон, БНХАУ, БНСУ зэрэг Азийн өндөр хөгжилтэй орны ёс зүйн сургалтын агуулга, стандартыг харьцуулан монголын нөхцөлд бага ангид зөв амьдрахуйг, дунд ангид биеэ зөв авч явах ёс журам, ахлах ангид харилцааны болон иргэний ёс зүй заах ёстой” гэж шинэлэг санаа

¹⁶ Моригива Ясумото. (2007). Хуульчийн ёс зүй. Орч. Эрдэнэ Э., Уянга М. Ред. Нарантуяа Л., Урангоо Б. Улаанбаатар, Мөнхийн үсэг, 14.

¹⁷ Нитобэ Иназо. (2007). Бүшидо Япон үндэстний ёс зүйн цогц. Орч. Төмөрбаатар Д. Улаанбаатар, Адмон принт.

¹⁸ Золзаяа М. (2008). “Бүшидо” ёс зүйн сургаал. МУИС. Философи, шашин судлал. №289 (51), 42-46.

¹⁹ Дарьхүү Р., Оюунцэцэг Б. (2009). Ёс зүйн боловсролын асуудалд. Философи, шашин судлал. №308 (51), 113.

дэвшүүлжээ.²⁰ Б.Оюунцэцэг, Ш.Диваа нар “Сурагчдын нас сэтгэл зүйн онцлогт тулгуурласан ёс суртахууны боловсролын заах арга зүйн асуудал” өгүүлэлдээ Японы бага сургуулийн ёс суртахууны хичээлд нас, сэтгэл зүйн онцлогийг харгалзан амьдралтай холбох, өөрийнхөө тухай бодох цаг олгох, багаар ажиллуулах, үнэлгээ тавихгүй байх, илэн далангүй ярилцах боломжийг бүрдүүлэх зэрэг²¹ хүүхдийн идэвхтэй суралцахуйд нөлөөлж буй, гэтэл манайд академик мэдлэг олгоход илүү чиглэсэн сул талтайг шүүмжилсэн байна.

Б.Оюунцэцэг Японы ёс суртахууны боловсролд бусдын байр сууринаас бодож, бусдыг ойлгох чадвар нь ёс суртахууныг хөгжүүлдэг, бусдын үзэл бодолтой тулгарч, харилцах явцад ёс суртахууны сэтгэлийн чиг хандлага (moral sentiment) аяндаа хөгждөг гэж үздэг. Иймд ёс суртахууны боловсролыг хэрэгжүүлэхдээ ёс суртахууны сэтгэлийн чиг хандлагыг (дотоод итгэл үнэмшил) бусдын сэтгэл санааны байдал (зовлон, жаргал)-ыг хуваалцаж, хамт мэдрүүлэх-sympathy замаар хөгжүүлэхэд анхаарч, хүүхдийн сэтгэлийг хөндөхүйц сургалтын материалыг их ашигладаг²² гэж үзжээ. “Сэтгэлийн чиг хандлага” нь мэдлэг, оюун ухаан, мэдрэхүй, мэдрэмж, сэтгэл хөдлөл, хүсэл эрмэлзэл зэргийг бүгдийг хамруулсан ухагдахуун бөгөөд аз жаргалд хүрэхэд зайлшгүй шаардагдах хүчин зүйл. Сүүлийн үед манайд сэтгэлээ жолоодох арга, ур чадварыг ёс зүйн боловсролтой андуурах болсон нь сайтар нягтлаагүй шууд хуулбарласан байж болох төдийгүй “зүрх сэтгэлийн боловсрол” гэдэг нэр томъёог сурах бичиг, судалгааны бүтээлд хэрэглэж буй нь хэр оновчтой вэ бодолцууштай.

Японы ёс суртахууны боловсролын хүрээнд сэтгэлийн асуудлыг анхаардгийг онолын үүднээс ёс зүйн сентиментализм гэж тайлбарлаж болох юм. Энэ нь шинэ үеийн европын ёс зүй дэх хандлага бөгөөд ёс суртахууныг ёс суртахууны мэдрэмж (мэдрэмж эсвэл сэтгэл хөдлөл) дээр тулгуурлан бүрэн буюу хэсэгчлэн тайлбарладаг үзэл. Анх XVIII зууны эхээр английн философич К.Шефтсберийн философи, ёс зүйд “ёс суртахууны мэдрэмж” гэсэн нэр томъёо хэрэглэгдсэн гэж үздэг. Тэрээр танин мэдэхүй-үнэлгээний чадварыг тодорхойлохын тулд “ёс суртахууны мэдрэмж” гэсэн нэр томъёог үндэслэсэн, ёс суртахууны мэдрэмжээр сайн мууг ялгаж, сайн үйл хийж сэтгэл ханамж авах болно гэж үзжээ. Ёс зүйн сентименталистуудын энэ хандлагыг 1980-аад оны үед үүссэн бусдыг энэрэх ёс зүйг дэмжигчид хүлээн зөвшөөрдөг. Ёс зүйн сентиментализмын

²⁰ Дарьхүү Р., Оюунцэцэг Б. (2009). *Ёс зүйн боловсролын асуудал*. МУИС. Философи, Шашин судлал. ЭШБ. №371 (65).

²¹ Оюунцэцэг Б., Диваа Ш. (2012). *Сурагчдын нас сэтгэл зүйн онцлогт тулгуурласан ёс суртахууны боловсролын заах арга зүйн асуудал*. ШУА-ийн ФСЭХ, Эрдмийн ертөнц (Academiae). 1 (06), 31-39.

²² Оюунцэцэг Б. *Альтруизмын талаар авч үзэх нь*. (2014). ШУА-ийн ФСЭХ, Философи, эрхийн судлал. 31-39.28-35 дахь тал.

шүүмжлэлд И.Кант онцгой үүрэг гүйцэтгэсэн бөгөөд бүтээлүүддээ ёс суртахууны мэдрэмжийн субъектив, түгээмэл бус шинж чанарыг байнга онцолдог байв.²³ Сентиментализмын үүднээс ёс суртахууны ухамсрын төвд сэтгэлийг тавих хандлага япончуудын ертөнцийг үзэх үзэл, философи сэтгэлгээнийх нь онцлогоос хамаарч байна гэж дүгнэхэд хүрлээ.

Японы БШУЯ-ы дэргэдэх ёс суртахууны боловсролыг шинэчлэлийг хэлэлцэх зөвлөлийг 2013 онд боловсруулсан тайланд тусгагдсан 2018 оноос шинээр нэвтрүүлэх “Ёс суртахуун” хичээлийн онцлог, боловсон хүчин, сургалтын материал, үнэлгээ, манайд туршлага болгон суралцах боломжийн талаар үзэл бодлоо илэрхийлсэн нь чухал ач холбогдолтой болжээ.²⁴ Японд ёс суртахууны боловсролд эх оронч үзлийн талаар төдийлөн дурддаггүй талаар 19-20 насны 123 япон оюутнаас эх оронч үзлийн талаарх ойлголтыг нь тодруулах судалгааны дүнгээр гаргажээ. “Эх оронч үзэл”-ийг төлөвшүүлэхдээ үндэсний соёл, уламжлал, олон улсын байр суурь, бусдын соёлыг хүндэтгэх, дэлхийн энх тайван, хүн төрөлхтний аз жаргал зэрэг ойлголттой холбож үздэг. Судалгаанд оролцогчид бага, дунд, ахлах сургуульдаа эх оронч үзлийг суралцаагүй гэж 69% нь үзсэн ч, 47% нь эх оронч үзэлтэй, 67% нь Япон орноор бахархдаг гэж хариулсан бөгөөд эх оронч үзэлд шүүмжлэлтэй ханддаг, улс төрийн шинж чанартай гэсэн хандлага давамгайлдаг ба энэ асуудалд няхуур ханддаг, эх оронч үзэл ба эх орноороо бахархах нь ялгаатай гэдэг, эх оронч үзлийг хүн төрөлхтний хэмжээнд өргөжүүлж боддог, дэлхийн энх тайвныг эрхэмлэж байгаа бол жинхэнэ эх оронч үзэл, бусдыг өөрийн адил үзэх, бусадтай хамтран ажиллах сэтгэлгээтэй болсон үед эх орноо хайрлах сэтгэлгээтэй байна. Энэ нь олон улсын байр сууринаас дэлхийн энх тайван, хүн төрөлхтний аз жаргалд хувь нэмэр оруулах иргэнийг төлөвшүүлнэ гэсэн боловсролын хөтөлбөрийн зорилго сайн үр дүнтэй хэрэгждэг бололтой²⁵ гэж дүгнэжээ.

Боловсрол судлаач, доктор (Sc.D) О.Пүрэв “2014 оны 9-р сарын 1-ээс ЕБС-ийн 1-5-р ангид ёс суртахууны тусгайлсан цагт ёс суртахууны эхийг сурагчид багштайгаа хамтран унших, ярилцах, хэлэлцэх, эргэцүүлэх замаар зөв ёс суртахуунтай болох сэдэл, зан үйлд суралцах юм. Эхүүдэд ёс суртахууны асуудлыг олон талаас нь бодох, хэлэлцэх, шийдвэрлэх кейсүүд туссан... Бага боловсролын ёс зүйн сургалтын хөтөлбөрт агуулга нь: өөртэйгөө, бусад хүмүүстэй, нийгэмтэй, байгаль орчинтой ёс суртахуунтай харилцах гэсэн дөрвөн хүрээгээр туссан. Ёс суртахууны

²³ Апресян Р.Г. Этический сентиментализм. <https://iphlib.ru/library/collection/newphilenc/document/HASH017fcfe8ee8ab8c1b1321f7f>. 2022.12.15.

²⁴ Оюунцэцэг Б. (2015). Япон дахь ёс суртахууны боловсролын туршлага, шинэчлэлийн бодлого. Монгол дахь ёс суртахууны боловсролын тулгамдсан асуудал. ЭШХ-ын эмхэтгэл. Улаанбаатар, Ган зам пресс, 115-126.

²⁵ Оюунцэцэг Б. (2015). Эх оронч үзлийг төлөвшүүлэх боловсрол болон ёс суртахууны талаар эргэцүүлэх нь. Шинжлэх ухаан, амьдрал. №01. 53-54 дэх тал.

эхийг бага ангийн бүх хичээлтэй үйл ажиллагаагаар холбож өгнө. Чухамдаа сурагчийн ёс суртахуунтай үйл бол бүх хичээлээр суралцах үйл ажиллагааны үндсийн үндэс гэдэг концепцийг баримталсан”²⁶ хэмээн тэмдэглэсэн буй. Энэ байр суурь нь Японы ёс суртахууны боловсролын туршлага дээр үндэслэсэн шинэчлэл байлаа.²⁷ Манайд Японы ёс суртахууны боловсролын судалгаа тодорхой хэмжээнд хийгдэж, сургалтын хөтөлбөрт санаа нь туссан байна. Японы сургуулиудад хэрэглэдэг “Сэтгэлийн дэвтэр” буюу “**Кокоро но нотэ**” сурах бичгийн жишээн дээр Финляндын Хелсинкийн Их сургуулийн профессорууд ёс суртахууны боловсрол олгож байгаа туршлагыг нарийвчлан судалж “Шинэ Монгол” сургуулийн сургалтын хөтөлбөр, сурах бичигт тусгаад байгаа²⁸ ажээ. УИХ-ын Тамгын газраас 2021 онд “Япон лугаа адил хөгжье-Японтой хамт суралцахуй хөгжлийн үйл явц” таван удаагийн цуврал хэлэлцүүлгээр Японы ёс зүйг үлгэр жишээ болгож суралцах хэрэгцээ байгааг тэмдэглэсэн байна. Гэхдээ хуулбарлахгүйгээр монголын онцлогтойгоо нийцүүлэх хэрэгтэйг судлаачид онцолжээ.

Хироикэ Чикүро хэмээх эрдэмтэн үндсийг нь тавьсан Ёс суртахуун судлалын (Moralogy) хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор Б.Оюунцэцэг 2016 онд “Ёс суртахууны удирдамж”, “Ёс суртахууны шинжлэх ухааны ерөнхий онол” хэмээх насан туршийн боловсролын сурах бичгүүдийг монгол хэлээр орчуулж, редакторлан хэвлүүлжээ. Эдгээр сурах бичигт ёс суртахууны онол, практикийн сэдвүүдийг тайлбарласан бөгөөд ёс суртахууны шинжлэх ухааны зорилт нь энгийн болон дээд ёс суртахууны зарчим, агуулга, хэрэгжүүлэх аргыг харьцуулан судлахын зэрэгцээ ёс суртахууныг хэрэгжүүлэх үр нөлөөг шинжлэх ухаанчаар тодорхойлоход оршино²⁹ гэж тодорхойлжээ. Тухайлбал, “Ёс суртахууны удирдамж” сурах бичиг найман бүлэг, 33 дэд сэдвээс бүтэж байна. Японд ЕБС-д багшлах эрх авахын тулд “Ёс суртахууны онол, заах арга зүй” хичээл заавал үзсэн байх шаардлага тавигддаг байна.³⁰ Манай орны хувьд ч тодорхой туршлага бий. Тухайлбал, 1989 онд Д.Дашцэдэн, Д.Дашжамц нар хамтран “Эрх зүй, ёс суртахуун заах аргын зөвлөмж”-ийг хэвлүүлсэн, 1999 онд Тэнгэр дээд сургуульд “Ёс зүй”, “Ёс зүй заах арга зүй” гэж хичээл зааж

²⁶ МУИС. (2014). Монгол дахь ёс зүйн сургалт, судалгааны өнөөгийн байдал, тулгамдсан асуудал. ЭШХ-ын эмхэтгэл. Улаанбаатар, Ган зам пресс.

²⁷ Дарьхүү Р., Золзаяа М. (2022). Монгол дахь ёс суртахууны боловсролын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал. ШУА-ийн Философийн хүрээлэн. Ёс суртахууны боловсролд холбогдох зарим асуудал. Судалгааны товхимол. Улаанбаатар, Соёмбо принтинг.

²⁸ Галбадрах Ж. Японы зүрх сэтгэлийн боловсрол олгодог туршлагаас суралцах нь. <https://www.parliament.mn/nn/14923>.

²⁹ Ёс суртахууны шинжлэх ухааны ерөнхий онол. Насан туршийн боловсролын сурах бичиг. Орч., ред. Оюунцэцэг Б. Ёс суртахууны шинжлэх ухааны хүрээлэн. Изава ХК, Токио хот, 2016. 2 дахь тал.

³⁰ Оюунцэцэг Б. Японд ЕБС-д багшлах эрх авахын тулд “Ёс суртахууны онол, заах арга зүй” хичээл үзсэн байх шаардлагатай байдаг. <https://ikon.mn/n/2c9c>. 2021.09.30.

байсан юм. Энэ мэт ажлыг сайжруулж үргэлжлүүлэхгүй тасалдуулдаг боловсролын салбар дахь зарим гажуудлыг бусад орны туршлагаас суралцан нөхөж буй эрдэмтдийн хичээл зүтгэл нь тодорхой хугацааны дараа үр дүнгээ өгнө гэдэгт найдаж байна. Жишээ нь, Японы албан тушаалтан гэм буруугаа хүлээж уучлал гуйж буйг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэй мэдээлж, олон нийт таатай хандан эерэг үнэлгээ өгсөн байдаг. Иймээс нийгмийн сэтгэл зүйн ийм хандлагыг давуу тал болгож, нийтийн ёс суртахууны ухамсрын түвшнийг дээшлүүлэхэд үлгэр жишээ болгож таниулах нь чухал болой.

Дүгнэлт

1. Дорно дахины орнуудын шашин, утга соёлын харилцаа холбоог судлах ажлын нэг чиглэл нь японы философийн судалгаа мөн. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалд заасан "гуравдагч хөрш"-ийн бодлого хэрэгжиж, Япон Монголын харилцаа өргөжиж байгаа ч Японы философийн талаар цөөн тооны өгүүлэл, илтгэл, нэг сэдэвт бүтээлийг эс тооцвол ерөнхийдөө философийн сурах бичиг, гарын авлага, зарим орчуулгын номын түвшинд авч үзэх нь нийтлэг байна. Эдгээр бүтээлтэй танилцсан хүмүүст Японы зэн буддизм, шинто шашны түүх, арлын орны ард түмний соёлын ондоошил, үзэл санааны уламжлалыг хятад, барууны философитой холбож өөриймшүүлсэн талаар ерөнхий мэдлэг бий болсон нь тодорхой.
2. Манай эрдэмтдийн цөөн боловч судалгааны өгүүлэл, ном, өгүүлэл, илтгэл гаргаж буйд сайшаалтай хандаж, энэ талын судалгаа эхлэлийн шатанд, хомс байна. Үүнд, 1990-ээд оноос өмнө Японы философи нь хөрөнгөтний философийн чиглэлд хамаарах тул анхаарлын төвд ороогүй болон их дээд сургуулийн философийн хөтөлбөрт өрнийн философийн агуулга түлхүү ордог нь шууд нөлөөлж буй бөгөөд дорно дахины философи гэсэн сэдвийн хүрээнд энэтхэг, хятадын философийн голчилж байна. Нөгөө талаар хэлний асуудал буюу Японы философийн талаар суурь судалгаа хийхэд япон, санскрит, хятад хэл дээрх ном, сурвалжууд ашиглах шаардлага тавигдахтай холбоотой. Ялангуяа өнөөгийн Япон дахь тэргүүлэх философич эрдэмтдийн олон талт судалгаа, тухайлбал, Вацужи Тэцүрогийн "Ёс зүй"³¹ гэх зэрэг бүтээлийн тухай хэрэглэгдэхүүн гаргахад англи хэлт судалгаануудыг өргөн ашиглах боломжтой. Нэгэнт философийн академик судалгаа хийх хүний

³¹ Watsuji Tetsurō's Rinrigaku. Ethics in Japan. Translated by Yamamoto Seisaku and Robert E. Carter. State University of New York Press, 1996.

нөөцийн дутагдалтай учир япон судлаачидтайгаа хүчээ нэгтгэн хамтран ажиллах бүрэн боломжтой гэж үзэж байна.

Талархал: Монгол-Японы дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойд зориулсан энэхүү эрдэм шинжилгээний хуралд оролцуулж, Монгол дахь Японы философийн судалгааны тоймыг гаргах, цаашид анхаарах асуудлыг тодорхойлох санаа сэдлийг өгсөн ШУА-ийн Олон Улс судлалын хүрээлэнгийн Гуравдагч хөрш орон судлалын салбарт гүн талархал илэрхийлье.

Ном зүй:

1. Гүн Аюурзана. (2010). Зэн-Буддизм: Амьдралаас ангижрахуй. Улаанбаатар.
2. Дарьхүү Р., Эрдэнэбаяр Г. (2016). Философийн түүх. 4 дэх хэвлэл. Ред. Лодой Г., Оюунгэрэл Д. Улаанбаатар, Тотопресс.
3. Дарьхүү Р., Оюунцэцэг Б. (2009). Ёс зүйн боловсролын асуудалд. МУИС. Философи, шашин судлал. УБ., №308 (51).
4. Дарьхүү Р., Оюунцэцэг Б. (2010). Ёс зүйн боловсролын шинэчлэл. МУИС. Боловсрол судлал. №05.
5. Дарьхүү Р., Золзаяа М. (2022). Монгол дахь ёс суртахууны боловсролын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал. Ёс суртахууны боловсролд холбогдох зарим асуудал. Судалгааны товхимол. Улаанбаатар, Соёмбо принтинг.
6. (2016). Ёс суртахууны шинжлэх ухааны ерөнхий онол. Насан туршийн боловсролын сурах бичиг. Орч., ред. Оюунцэцэг Б. Ёс суртахууны шинжлэх ухааны хүрээлэн. Токио хот, Изава ХК.
7. (2016). Ёс суртахууны удирдамж. Насан туршийн боловсролын сурах бичиг. Орч., ред. Оюунцэцэг Б. Ёс суртахууны шинжлэх ухааны хүрээлэн. Токио хот, Изава ХК.
8. Золзаяа М. (2008). "Бүшидо" ёс зүйн сургаал. МУИС. Философи, шашин судлал. №289 (51).
9. Лхагвасүрэн Г. (2010). Сэтгэл төдийтний гүн ухаан. Ред. Чулуунбаатар Г. Улаанбаатар, Соёмбо принтинг.
10. Моригива Ясутото. (2007). Хуульчийн ёс зүй. Орч. Эрдэнэ Э., Уянга М. Ред. Нарантуяа Л., Урангоо Б. Улаанбаатар.
11. Насанжаргал Э. ба бус. (2011). Зэнгийн амьдрал. Улаанбаатар, Женерал принтинг.
12. Оюунгэрэл Д. (2007). Нишида Китаро ба ХХ зууны Японы философи. МУИС. Философи, шашин судлал. №288 (41).
13. Оюунгэрэл Д. (2008). Нишида Китарогийн философи дахь онтологийн үндсэн ойлголтууд. ХААИС-ийн Багш нарын эрдэм

шинжилгээний эмхэтгэл. Улаанбаатар.

14. Оюунгэрэл Д. (2009). Нишида Китарогийн философийн үндсэн ойлголтууд. МУИС. Философи, шашин судлал. Улаанбаатар. №318 (55).
15. Оюунгэрэл Д. (2010). Сайн үйл нь хүний амьдралын үндэс болох тухай Нишида Китарогийн үзэл. Philosophy: Theory and practice. Улаанбаатар.
16. Оюунгэрэл Д. (2013). Нишида Китарогийн философи дахь шашны тухай үзэл баримтлалаас. МУИС. Философи, шашин судлал. Vol 14, (385).
17. Оюунцэцэг Б., Диваа Ш. Сурагчдын нас сэтгэл зүйн онцлогт тулгуурласан ёс суртахууны боловсролын заах арга зүйн асуудал. ШУА-ийн ФСЭХ, Эрдмийн ертөнц (Academiae). 2012/1 (06).
18. Оюунцэцэг Б. (2015). Эх оронч үзлийг төлөвшүүлэх боловсрол болон ёс суртахууны талаар эргэцүүлэх нь. Шинжлэх ухаан, амьдрал. №01.
19. Оюунцэцэг Б. (2014). Альтруизмын талаар авч үзэх нь. ШУА-ийн ФСЭХ, Философи, эрхийн судлал. Боть 29, 31-39.28-35.
20. Саранцэцэг М. (2015). Японы философи сэтгэлгээний түүхэн тойм. Редактор Р.Дарьхүү. Улаанбаатар.
21. Сато Чиэ. (2021). Харвардын япон судлал. Япон хүн гэж хэн бэ?. Орч. Тэмүүлэй М. Улаанбаатар, Монсудар.
22. Сэржав Б., Загдцэсэм У., Болормаа М., Сосорбурам А. (2022). Монгол, Японы харилцаа. Он дарааллын товчоон 1972-2022. Эмх. ШУА-ийн ОУСХ. Улаанбаатар, Бэмби сан.
23. Фүкизава Юкичи. (2014). Эрдмийг эрхэмлэх ухаан. Орч. Жаргалсайхан О. Ред. Даш-Ёндон Б. Улаанбаатар, Адмон ХХК.

Цахим эх сурвалж:

1. Апресян Р.Г. Этический сентиментализм. <https://iphlib.ru/>. 2022.12.15.
2. Галбадрах Ж. Японы зүрх сэтгэлийн боловсрол олгодог туршлагаас суралцах нь. <https://www.parliament.mn/nn/14923>. 2022.12.15.
3. Волкер Герхардт: Үнэндээ Ницше, Кант хоёр маш төсөөтэй. Орч. Золзаяа М. <http://mongolianphilosophy.org/133.html>. 2022.12.29.
4. Оюунцэцэг Б. Японд ЕБС-д багшлах эрх авахын тулд "Ёс суртахууны онол, заах арга зүй" хичээл үзсэн байх шаардлагатай байдаг. <https://ikon.mn/n/2c9c>. 2021.09.30.
5. Tomomi Asakura. Japanese Philosophy. <https://www.oxfordbibliographies.com>. 2022.12.15.